

БАТЛАВ.
ХЭНТИЙ АЙМГИЙН БАЯНМӨНХ СУМЫН
ЗАСАГ ДАРГА



Б.ЗОЛЖАРГАЛ

**ХЭНТИЙ АЙМГИЙН БАЯНМӨНХ СУМЫН ТӨВ ДОТОРХ 2.3 КМ АВТО ЗАМЫН ИНЖЕНЕРИЙН
НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ
АЖЛЫН ДААЛГАВАР**

2023 оны 4 сарын 15-ны өдөр	№	Хэнтий аймаг, Баянмөнх сум
1. Зураг төсөл боловсруулах үндэслэл		Хэнтий аймгийн Баянмөнх сумын төвд хатуу хучилттай авто зам тавих
2. Байршил		Хэнтий аймгийн Баянмөнх сум
3. Хөрөнгө оруулалтын эх үүсвэр		Улсын төсөв
4. Замын техникийн ангилал, замын зэрэг		Нутаг дэвсгэрийн туслах гудамж зам
5. Замын хучилт		Хучилтийн хийцийг зургийн ерөнхий инженерийн техникийн шийдэл ба тооцоогоор сонгоно.
6. Төлөвлөлтийн норм		<ul style="list-style-type: none">• “Авто зам төсөллөх” ЗЗНБД 22-004-2016• “Хот тосгоны төлөвлөлт ба барилгажилт” БНБД 30-01-04• “Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл” АЗУАГН 2.01.01-2004• “Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх” БНБД 22.01.01*/2006• “Барилга байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл” БНБД 11-07-04-ийн II хэсэг инженер геодезийн ажил “Геодезийн ажил” БНБД 3.01.03-88

- “Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага” MNS4597:2014
- “Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио хашилт чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм” MNS4596:2014
- “Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль /БД 31-101-04/ барилгын дүрэм
- “Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар” MNS 6056:2006

7. Зураг төсөл зохиох үе шат, хугацаа

Нэг үе шаттай, 2023 оны 6 дугаар сард багтаан гүйцэтгэнэ

8. Зураг төслийн иж бүрдэл

- “Геодези зурагзүйн тухай” хуулийн 6.1.3 дугаар заалт, “Барилга байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл” БНБД 11-07-04-ийн II хэсэг инженер геодезийн ажил, “Геодезийн ажил” БНБД 3.01.03-88-д тавигдах шаардлагын дагуу байр зүйн хэмжилтийн ажлын тайлан
- Инженер-геологийн судалгааны ажлын тайлан
- Дараах хэсгүүдийг нэгтгэсэн Авто замын ажлын иж бүрэн зураг төсөл:
 - Авто зам, хиймэл байгууламжийн ажлын иж бүрэн нарийвчилсан зураг төсөл
 - Авто замын гэрэлтүүлгийн зураг төсөл
 - Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын техникийн шаардлага;
 - Замын зурваст орсон инженерийн байгууламж, цахилгаан, холбооны шугам сүлжээний техникийн нөхцөлийг холбогдох байгууллагуудаас авах, шаардлагатай тохиолдолд нүүлгэн

- шилжүүлэх, хүчитгэх, өндөрсгөх ажлын тоо хэмжээ, зардал;
- Ажилбар тус бүрийн болон Барилгын ажлын нэгдсэн тоо хэмжээ
 - Тайлбар бичиг (хучилтын тооцоо, ажлын нэр, тоо хэмжээ, авто замын зураг төслийн иж бүрдэл, холбогдох захирамж, техникийн нөхцөл, магадлалын дүгнэлт гэх мэт)
 - Авто зам, замын байгууламжийн нэгдсэн төсөв
 - Зам барилгын ажилтай холбоотой газар олгосон орон нутгийн засаг захиргааны захирамж болон бусад зөвшөөрөл, техникийн нөхцөлүүд;
 - Зураг төслийн иж бүрдэл тус бүрийг баталгаажуулсан Магадлалын ерөнхий дүгнэлт

9.Захиалагч байгууллага

Хэнтий аймгийн Баянмөнх сумын засаг даргын тамгын газар

10.Онцгой нөхцөл

- Явган хүний зам, ногоон байгууламж, гэрэлтүүлгийн өнгө төрхийг тухайн орчны харагдах нөхцөл байдалтай уялдуулж төлөвлөх
- Хөндлөн огтлолыг орчны нөхцөлтэй уялдуулан төлөвлөх, барилга байгууламж, айлууд руу орох орц, гарцны шийдлийг оновчтой хийх
- Авто замын төлөвлөлтийг огтлолцож буй болон холбогдож буй бүх талын замтай уялдуулах
- Хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган тэмдэг, тэмдэглэгээ, хөдөлгөөн зохицуулалтын тоноглолыг иж бүрэн байлаар зураг төсөлд тусгах

- Уулзвар, хөдөлгөөн зохион байгуулалтыг цогц шийдвэрлэх
- Авто замын гэрэлтүүлгийн төлөвлөлт хийж, ажлын зургийг боловсруулах
- Авто замын гэрэлтүүлгийг эрчим хүчний хэмнэлттэй, шар тусгалтай, чанарын шаардлага хангасан "LED" технологиор шийдвэрлэх
- Инженерийн нарийвчилсан зураг төслийн иж бүрдлийг Захиалагчаар хянуулж, зөвшилцсөний дараа Магадлалд оруулна.
- Инженерийн нарийвчилсан зураг төслийн иж бүрдлийг эх хувь 1ш, хуулбар хувь 2ш, тоон хэлбэрээр /DWG болон PDF/ хүлээлгэж өгнө.

Хянасан:

Хэнтий аймгийн Баянмөнх сумын засаг даргын тамгын газрын даргыг түр орлон гүйцэтгэгч

Боловсруулсан:

Хэнтий аймгийн Баянмөнх сумын газрын даамал



У.ДӨЛГӨӨН-УЧРАЛ

Ө.НЯМЦЭЦЭГ

Ө.НЯМЦЭЦЭГ